



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/787

Булган сум

**2025 оны шилдэг ажилтан, шилдэг хөрөнгө
оруулагч шалгаруулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 тогтоолоор батлагдсан "Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2025 оны А/777 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн оны шилдгүүд шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны шилдэг ажилтан, шилдэг хөрөнгө оруулагчаар шалгарсан аж ахуйн нэгжийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Оны шилдгүүдийг шагнах урамшуулалд шаардагдах 15,700,000 (арван таван сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Шилдэг ажилтнуудыг шагнаж урамшуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Насанжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

2025 ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТАН, ШИЛДЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

- 1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын Аймгийн шилдэг түшээ**
 - Индрээгийн Ичинхорлоо (Бүрэгхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга)
- 2. Төрийн захиргааны салбарын оны шилдэг ажилтан**
 - Цогтсайханы Энх-Амгалан (Нийгмийн даатгалын газрын дарга)
- 3. Хууль, хяналтын салбарын оны шилдэг ажилтан**
 - Дашцэрэнгийн Төрбат (Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, Цагдаагийн хошууч)
- 4. Санхүүгийн салбарын оны шилдэг ажилтан**
 - Жам-Осорын Оюун (Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч)
- 5. Боловсролын салбарын оны шилдэг ажилтан**
 - Чойжиндондогын Сарантуяа (Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн Нийгмийн ухааны багш)
- 6. Эрүүл мэндийн салбарын оны шилдэг ажилтан**
 - Хишигсүрэнгийн Олзмөнх (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Их эмч)
- 7. Соёл, спортын салбарын оны шилдэг ажилтан**
 - Түмэнбаярын Бэхтөр (Аймгийн Музейн захирал)
- 8. Нийгмийн хамгаалал, иргэний нийгмийн байгууллагын салбарын оны шилдэг ажилтан**
 - Гүрбадамын Одончимэг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Ахлах мэргэжилтэн)
- 9. Үйлдвэрлэл, үйлчилгээний оны шилдэг ажилтан**
 - Нэргүйн Амгаланбаатар (“Шидэт урлаач” ГҮТББ-ын тэргүүн, “Монголжингоо” салоны үсчин)
- 10. Дэд бүтцийн салбарын оны шилдэг ажилтан**
 - Энхбаярын Нямсүрэн (“Булган Мээж” ОНӨХХК-ийн Ерөнхий инженер)
 -
- 11. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын оны шилдэг ажилтан**
 - Ж.Адилбиш (Орхон сумын иргэн, фермер)

12.Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын оны шилдэг ажилтан

- Б.Алтансүх (Булган сумын Сум дундын ойн ангийн дарга)

13.Шилдэг хөрөнгө оруулагч (Нийгмийн салбар)

- “Азийн хөгжлийн” банк

14.Шилдэг хөрөнгө оруулагч (Хөдөө, аж ахуйн салбар)

- “Интосэ” ХХК Сэлэнгэ сум

15.Шилдэг хөрөнгө оруулагч (Дэд бүтцийн салбар)

- “Биг Бюлдинг Констракшн” ХХК

16.Шилдэг хөрөнгө оруулагч (Үйлдвэр үйлчилгээний салбар)

- “Элбэг-Эд” ХХК “Дрийм лоунж”

17.Шилдэг хөрөнгө оруулагч (Аялал жуулчлалын салбар)

- “Бүтэлэ ресорт” Хутаг-Өндөр сум